

**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГААС  
БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ДӨРВӨЛСӨН ГЭРЭЭ**

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дахь заалтын дагуу нэг талаас Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг дарга А.Мөнхбайгаль/Цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас тус сумын Салхит нэртэй газарт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч /Цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/ Баян-Эрдэс компанийн захирал Н.Ариунбилэг, гуравдагч талаас Монголын Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гүйцэтгэх захирал Э.Оюунболд, дөрөвдөгч талаас "Нутгийн хишиг" нөхөрлөл ТББ /Цаашид "Бичил уурхай эрхлэгч" гэх/-ыг төлөөлж ахлагч А.Сүхбат нар /Цаашид хамтад нь "Талууд" гэх/ харилцан тохиролцож 2024 оны 05 сарын 10-ны өдөр энэхүү дөрвөлсөн гэрээг /Цаашид "Гэрээ" гэх/ Хэнтий аймгийн Норовлин суманд байгуулав.

**Нэг: Ерөнхий зүйл**

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн талбайгаас бичил уурхай эрхлэгчид алт олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээг 2024 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 04 жилийн хугацаагаар байгуулав.

**Хоёр: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг**

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Тусгай зөвшөөрөлөөр олгогдсон талбайн дор дурдсан солбицол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн бичил уурхай эрхлэгч этгээдэд ашиглуулах

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	112,21,45	48,15,07.3
2	112,21,48.8	48,14,56.1
3	112,21,43.3	48,14,57.8

2.1.2. Бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах баяжуулах талбайн байршлыг тогтоох

2.1.3. Бичил уурхай эрхлэгчийг гэрээнд заасан солбицолын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих

2.1.4. Бичил уурхай эрхлэгчийн аюулгүй байдлын дүрмийг мөрдөлтөнд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах

2.1.5. Бичил уурхай эрхлэгчид нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхэд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

2.1.6. Бичил уурхай эрхлэгч болон Засаг даргыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

2.1.7. Бичил уурхай эрхлэгчээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхыг шаардах



2.1.8. Бичил уурхай эрхлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах асуудлыг талуудад гаргах

2.1.9. Бичил уурхай эрхлэгчийн татвар даатгалын асуудлыг хариуцахгүй байх

2.1.10. Гэрээт талбайгаас олборлосон ашигт малтмалыг худалдахдаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэхийг шаардах

2.1.11. Бичил уурхай эрхлэгчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 сарын дотор геологи, уул урхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх

### **Гурав: Сум (Дүүрэг)-ын Засаг даргын хүлээрх эрх, үүрэг**

3.1. Сум (Дүүрэг)-ын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлд зааснаас эрх үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) эрхлэгчдэд "Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм"-ийг таниулах, ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах

3.1.2. Хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох

3.1.3. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

3.1.5 Бичил уурхай эрхлэгчийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий хуулийн этгээдэд борлуулж байгаа эсэхэд хяналт тавих

3.1.6 Бичил уурхай эрхлэгч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

3.1.7. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, бичил уурхайн аюулгүй байдлын дүрийг дагаж мөрдөөгүй тохиолдолд бичил уурхай эрхлэгчийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож талуудад гэрээг цуцлах санал гаргах

3.1.8 Хууль тогтоомжоор олгогдсон бусад үүргээ хэрэгжүүлэх

### **Дөрөв: Бичил уурхай эрхлэгчийн эрх, үүрэг**

4.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1 Гэрээт талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах

4.1.2 Гэрээгээр олгосон талайд зөвхөн бүртгэлтэй гишүүнийг ажиллуулах

4.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх

УЛААНБААТАР  
МОНГОЛ  
ГЧИЛ У  
НДСЭН  
ХОЛ  
ГҮ  
ТТБ0132

4.1.4 Сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон суурьшлийн талбайд амьдрах, тогтоосон газарт хог хаягдлын цэг байгуулах

4.1.5 Олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоосон талбайд болон төвлөрсөн баяжуулах цехэд гүйцэтгэх

4.1.6 Гэрээт талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах

4.1.7 Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, ослоос урьдчилан сэргийлэх

4.1.8 Ашигт малтмалын олборлох үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахгүй байх

4.1.9 Байгаль орчныг хамгаалж гол горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх, нөхөн сэргээлт хийх

4.1.10 Ажилтнуудын дунд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах

4.1.11 Олборлосон ашигт малтмалыг эрх бүхий этгээдэд борлуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэх.

4.1.12. Холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлөх, бичил уурхайчдыг нийгмийн даатгалд хамруулах

4.1.13. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргаас шаардах

4.1.14. Хууль тогтоомжийг мөрдөх, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх

#### **Тав: Харилцан хүлээх үүрэг**

5.1. Гэрээг цулах үндэслэл бий болсон тохиолдолд талуудад гэрээг цуцлах тухай саналаа бичгээр хүргүүлнэ

5.2. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл бичил уурхай эрхлэгч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин бусад этгээдэд хохирол учирвал уг хохиролыг буруутай тал барагдуулна.

#### **Зургаа: Маргаан шийдвэрлэх**

6.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

6.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд үүссэн маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

#### **Долоо: Гэрээний хүчин төгөлдөр болох**

ХҮБН  
УРХА  
/ДЭЭН  
600  
/ББ  
А. 8107884

7.1 Энэхүү гэрээ нь 2024 оны 06 сарын 01 өдрөөс .....2024 оны 10 сарын 01 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Гэрээний хүчинтэй хугацаанд ашигт малтмалын ашиглалтын тухай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж, "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3.2.10-т заасны дагуу орон нутагт хүлээлгэн өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

7.4. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаарх саналаа аль нэг тал нөгөө талууддаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө талууд нь ажлын 20 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.5. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр 1 хувийг хадгална.

### Найм: Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

8.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

### Гэрээ байгуулсан:

Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг дарга

...../А.Мөнхбайгал/

/тамга, тэмдэг/ /гарын үсэг/

"Баян-Эрдэс" ХХКомпанийг төлөөлж захирал

...../Н.Ариунбилэг/

/тамга, тэмдэг/ /гарын үсэг/

Монголын Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гүйцэтгэх захирал

...../В.Нарансунт/

/тамга, тэмдэг/ /гарын үсэг/

"Нутгийн хишиг" нөхөрлөлийн ахлагч

...../А.Сүхбат/

/тамга, тэмдэг/ /гарын үсэг/



1949  
10  
ЭР